| 1200042       | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                | 0.00                  | 113,006,693.00        | (113,006,693.00)        |
| <b>4</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  | 0.00                  | <b>72,200,058.00</b>  | <b>(72,200,058.00)</b>  |
| <b>5</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b> | 0.00                  | <b>72,200,058.00</b>  | <b>(72,200,058.00)</b>  |
| <b>62</b>     | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                  | 42                    | 35                    | 7                       |
| 620001        | Удирдах ажилтан  | 2                     | 2                     | 0                       |
| 620002        | Гүйцэтгэх ажилтан  | 28                    | 21                    | 7                       |
| 620003        | Үйлчлэх ажилтан  | 12                    | 12                    | 0                       |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 20-ны хооронд Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн аудитор А.Цэрэнчимэд, аудиторын туслах Ч.Мөнхбулган нар гүйцэтгэж, хяналтыг чанарын менежер С.Андреш, Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн захирал В.Даваасүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Стандарт дүгнэлт аудит ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 01/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нь Алтанбулаг чөлөөт бүсэд чөлөөт бүсийн хуулийн хэрэгжилтийг хангуулснаар, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа үйлчилгээний шинэ салбарыг нэмэгдүүлэх, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх зэрэг төрийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Чөлөөт бүсийн тухай хуульд 2021 оны 12 дугаар сард орсон нэмэлт өөрчлөлт;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд Шадар сайдын хэрэг эрхлэх газраас санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 1,758,283.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,582.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,113,304.8 мянган төгрөгөөр буюу 19.8 хувиар буурч, материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл      | Эцсийн үлдэгдэл     | Өөрчлөлт             |
|---|---------------------|---------------------|----------------------|
| Б   | 1                   | 2                   | 3=2-1                |
| Мөнгөн хөрөнгө                                    | 72,200.1            | 72,200.1            | 0.00                 |
| Авлага  | 423,999.2           | 242,249.4           | (181,749.8)          |
| Урьдчилгаа  | 0.00                | 0.00                | 0.00                 |
| Бараа материал                                    | 5,567.2             | 6,362.4             | 795.2                |
| Үндсэн хөрөнгө                                    | 22,201,043.3        | 21,268,693.1        | (932,350.2)          |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>22,702,809.8</b> | <b>21,589,505.0</b> | <b>(1,113,304.8)</b> |
| Өр төлбөр   | 72,200.1            | 72,200.1            | 0.00                 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 22,630,609.7        | 21,517,304.9        | (1,113,304.8)        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>22,702,809.8</b> | <b>21,589,505.0</b> | <b>(1,113,304.8)</b> |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага данс тайлант онд төлж барагдуулсан 38,014.5 мянган төгрөгөөр, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг, Сэлэнгэ, Төв аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны шийдвэрүүдийг үндэслэн тус бүсийн захирагчийн 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн А/80 дугаар захирамжаар хэрэгсэхгүй болгож найдваргүй авлагын алдагдлаар бүртгэсэн 143,735.3 мянган төгрөгөөр нийт 181,749.8 мянган төгрөгөөр буурсан;
- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалан 932,350.2 мянган төгрөгөөр буурсан;
- Засгийн газрын оролцоо данс үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалан 1,113,304.8 мянган төгрөгөөр буурсан;



Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 72,200.1 мянган төгрөг нь Комфорт импекс ХХК-ийн ажлын гүйцэтгэлийн баталгаа байна.

Энэ нь 2018 онд Комфорт импекс ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Сэлэнгэ аймгаас Алтанбулагийн чиглэлийн 25 км замд бохир усны шугамын хоолойн ажлын гүйцэтгэлийн баталгааг 3 жилийн хугацаатайгаар байршуулсан байна. Уг бохир усны шугамын хоолойд эвдрэл гэмтэл гарсан бөгөөд засварыг хийж гүйцэтгээгүй тул олгогдоогүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 699,692.1 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 699,692.1 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба тайлант онд чөлөөт бүсийн үйл ажиллагаа жигдрээгүй тул бусад эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 9,505.8 мянган төгрөгөөр бууруулан 690,186.3 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 690,186.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 626,476.7 мянган төгрөгийг зарцуулж, 63,709.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээний |  | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү    | Биелэлт |
|-----|--------------------------|--|------------|-----------|----------|---------|
|     | Код                      | Нэр  |            |           |          |         |
| 1   | 71201                    | Чөлөөт бүсийг хөгжүүлэх                        | 690,186.3  | 626,476.7 | 63,709.6 | 90.7    |
| 1.1 | 210                      | Үндсэн үйл ажиллагааны зардал                  | 686,667.5  | 622,957.9 | 63709.6  | 90.7    |
| 1.2 | 210604                   | Урсгал зардал                                  | 2,830.0    | 2,830.0   | 0.00     | 100.0   |
| 1.3 | 213204                   | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 688.8      | 688.8     | 0.00     | 100.0   |

Цалин болон нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 63,676.1 мянган төгрөгөөр, бусад зардлыг 33.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, төсвийн нийт гүйцэтгэл 626,476.6 мянган төгрөг буюу 90.7 хувьтай байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээ байхгүй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайланд хийх аудитын чиглэлд заасны дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардалд хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн “Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион

байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” 12 дугаар тогтоолын 2.4-т “худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого, төлөвлөлтийн газар (чөлөөт бүс, хилийн боомтын бодлогын хэлтэстэй)” гэж заасны дагуу тус байгууллага нь Эдийн засаг хөгжлийн яамны харьяанд шилжсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 26 нэр төрлийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд нийт 139 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул холбогдох албан тушаалтанд хариуцлага ногдуулах албан шаардлага хүргүүлэх.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Батлагдсан төсвийн урсгал зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсвийн зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хэмнэлттэй үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах, хэмнэлттэй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Иргэний хуулийн болон газар эзэмшүүлэх гэрээний заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс газрын төлбөрийн орлогын бүрдүүлэлтийг нягтлан бодох бүртгэлд үндэслэлгүй бүртгэсэн, авлагыг нэмэгдүүлсэн зөрчил илэрсэн.

Энэ нь Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1 “гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил”, газар эзэмшүүлэх гэрээний 5.11 “газар эзэмших эрхийн гэрчилгээ авсан аж ахуйн нэгж тухайн газрыг эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд чөлөөт бүс дотор үйл ажиллагаа эрхлээгүй, зохих зааврын дагуу төлбөрийг төлөөгүй тохиолдолд газар эзэмших эрхийн гэрээг хүчингүйд тооцон газрыг хураах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Иргэний хуулийн болон газар эзэмших гэрээний заалтыг хэрэгжүүлж, газрын төлбөрийн орлогыг нягтлан бодох бүртгэлд зөв бүртгэх, авлагыг барагдуулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардалд хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан заалт, Иргэний хуулийн болон газар эзэмших гэрээний заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй нь Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1-дэх заалт, газар эзэмшүүлэх гэрээний холбогдох заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 630.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчил илрүүлснээс 630.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад зөвлөмж өгч ажиллалаа.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад илүү олгосон төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл цалин 630.0 мянган төгрөгийг холбогдох ажилтанаар төлүүлсэн байна.

*Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/*

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |             | Биелэлт  |             | Зөрүү |     |             |
|-----------------|---------------------|-------------|----------|-------------|-------|-----|-------------|
|                 | Тоо                 | Дүн         | Тоо      | Дүн         | Тоо   | Дүн | Хувь        |
| Албан шаардлага | 1                   | 0.00        | 1        | 0.00        |       |     | 50.0        |
| Албан шаардлага | 1                   |             | 1        |             |       |     | 100         |
| <b>Нийт дүн</b> | <b>2</b>            | <b>0.00</b> | <b>2</b> | <b>0.00</b> |       |     | <b>75.0</b> |

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон зөрчилд өгсөн албан шаардлагын биелэлт 50 хувь, дотоод хяналтын ажилтан санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгээгүй зөрчилд өгсөн албан шаардлагын биелэлт 100 хувьтай байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1.Комфорт импекс ХХК-ийн 72,200.1 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааны дагуу тухайн ажилд гарсан эвдрэл гэмтлийг зассан эсэх, гүйцэтгэлийн баталгааны ажил гүйлгээг.

2.Газар эзэмшүүлэх гэрээний заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс газрын төлбөрийн 143,735.3 мянган төгрөгийн авлага үүссэн, шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болж, найдваргүй авлагын дансаар хааж төсвөөс үргүй зардал гарч байгаа эдгээр асуудлыг дараагийн аудитаар авч үзнэ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,735,648.5 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 1,724,692.2 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 10,956.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв.

Залруулагдаагүй 1 алдаа, зөрчлийн дүн 10,956.3 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг түвшнээс бага тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

##### 4.1 ЗАЛРУУЛСАН АЛДАА

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд өмнөх үеийн үр дүнгийн эхний үлдэгдлийг 1,388,335.7 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 76,036.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 260,320.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;

##### 4.2 АЛБАН ШААРДЛАГА

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангаар 5 байгууллагатай холбоотой 10,956.3 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Газрын төлбөрийн авлага үүссэн харилцагч тус бүрээр авлагын тооцоо хийж, баталгаажуулан, баримтжуулж байх албан шаардлага хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д   | Байгууллагын нэр                                | Аудитын код             | Алдаа, зөрчлийн утга  | Тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн утга  | Нийт алдаа, зөрчлийн дүн |                    | Үүнээс    |                    |               |             |                 |                 |                   |             |          |             |
|---|---|-------------------------|---|--|--------------------------|--------------------|-----------|--------------------|---------------|-------------|-----------------|-----------------|-------------------|-------------|----------|-------------|
|   |   |                         |   |  |                          |                    | Залруулга |                    | Төлбөрийн акт |             | Албан шаардлага |                 | Хариуцлага тооцох |             | Зөвлөмж  |             |
|   |   |                         |   |  | Тоо                      | Дүн                | Тоо       | Дүн                | Тоо           | Дүн         | Тоо             | Дүн             | Тоо               | Дүн         | Тоо      | Дүн         |
| <b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар</b>                          |   |                         |   |  |                          |                    |           |                    |               |             |                 |                 |                   |             |          |             |
| 1   | Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба | АХГ-2022/158/НА-СТА-ТШЗ | Санхүүгийн байдлын тайланд өмнөх үеийн үр дүнгийн эхний үлдэгдлийг дутуу илэрхийлсэн        | Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж баталгаажуулав. | 1                        | 1,388,335.7        | 1         | 1,388,335.7        |               |             |                 |                 |                   |             |          |             |
| 2   | Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба | АХГ-2022/158/НА-СТА-ТШЗ | Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг илүү илэрхийлсэн             | Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж баталгаажуулав  | 1                        | 76,036.0           | 1         | 76,036.0           |               |             |                 |                 |                   |             |          |             |
| 3   | Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба | АХГ-2022/158/НА-СТА-ТШЗ | Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг дутуу илэрхийлсэн      | Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулгыг санхүүгийн тайланд тусгаж баталгаажуулав.        | 1                        | 260,320.5          | 1         | 260,320.5          |               |             |                 |                 |                   |             |          |             |
| 4   | Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба | АХГ-2022/158/НА-СТА-ТШЗ | Тус байгууллага нь 5 байгууллагатай холбоотой авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. | Газрын төлбөрийн авлага үүссэн харилцагч тус бүрээр авлагын тооцоо хийж, баталгаажуулан, баримтжуулж байх албан шаардлага хүргүүлэх.       | 1                        | 10,956.3           |           |                    |               |             | 1               | 10,956.3        |                   |             |          |             |
| <b>Дүн</b>  |   |                         |   |  | <b>4</b>                 | <b>1,735,648.5</b> | <b>3</b>  | <b>1,724,692.2</b> | <b>0</b>      | <b>0.00</b> | <b>1</b>        | <b>10,956.3</b> | <b>0</b>          | <b>0.00</b> | <b>0</b> | <b>0.00</b> |
| <b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> |   |                         |   |  |                          |                    |           |                    |               |             |                 |                 |                   |             |          |             |

|                 |   |                         |   |  |          |                    |          |                    |          |             |          |                  |          |             |
|-----------------|---|-------------------------|---|--|----------|--------------------|----------|--------------------|----------|-------------|----------|------------------|----------|-------------|
| 1               | Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба | АХГ-2022/158/НА-СТА-ТШЗ | Тайлант онд нийт 139 мэдээллийг шилэн дансны онд нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.  | Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул холбогдох албан тушаалтанд хариуцлага ногдуулах албан шаардлага хүргүүлэх | 1        | 0.00               | 0.00     | 0                  | 0.00     | 0           | 0.00     | 1                | 0.00     | 0.00        |
| 2               | Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба | АХГ-2022/158/НА-СТА-ТШЗ | Батлагдсан зардлын урсгал зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.   | Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулаагүй, хэмнэлт гаргаж ажиллаагүй тул шаардлага хүргүүлэх.   | 1        | 0.00               |          |                    |          |             | 1        | 0.00             |          |             |
| 3               | Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба | АХГ-2022/158/НА-СТА-ТШЗ | Иргэний хуулийн болон газар эзэмшүүлэх гэрээний заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс газрын төлбөрийн орлогын бүрдүүлэлтийг нягтлан бодох бүртгэлд үндэслэлгүй бүртгэсэн, авлагыг нэмэгдүүлсэн зөрчил илэрсэн. | Цаашид Иргэний хуулийн болон газар эзэмших гэрээний заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, авлагыг барагдуулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.   | 1        | 143,735.3          |          |                    |          |             | 1        | 143,735.3        |          |             |
| <b>Дүн</b>      |   |                         |   |  | <b>3</b> | <b>143,735.3</b>   |          |                    |          |             | <b>2</b> | <b>143,735.3</b> | <b>1</b> |             |
| <b>Нийт дүн</b> |   |                         |   |  | <b>7</b> | <b>1,879,383.8</b> | <b>3</b> | <b>1,724,692.2</b> | <b>0</b> | <b>0.00</b> | <b>3</b> | <b>154,691.6</b> | <b>1</b> | <b>0.00</b> |





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 191/А 0150058

Улаанбаатар хот

АХГ - 2022/158/НА - СТА - ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Иргэний хуулийн болон газар эзэмшүүлэх гэрээний заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс газрын төлбөрийн орлого бүрдүүлэлтийг нягтлан бодох бүртгэлд үндэслэлгүй бүртгэсэн, авлагыг нэмэгдүүлсэн зөрчил илэрсэн.

Энэ нь Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1 "гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил", газар эзэмшүүлэх гэрээний 5.11-дахь"газар эзэмших эрхийн гэрчилгээ авсан аж ахуйн нэгж тухайн газрыг эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд чөлөөт бүс дотор үйл ажиллагаа эрхлээгүй, зохих зааврын дагуу төлбөрийг төлөөгүй тохиолдолд газар эзэмших эрхийн гэрээг хүчингүйд тооцон газрыг хураах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Иргэний хуулийн болон газар эзэмшүүлэх гэрээний заалтыг хэрэгжүүлж, газрын төлбөрийн орлогыг нягтлан бодох бүртгэлд зөв бүртгэх, авлагыг нэмэгдүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Захирагч Г.Ганзориг, Ерөнхий нягтлан бодогч Г.Балцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХҮК-ИЙН  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
А.ЦЭРЭНЧИМЭД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-197.Docx

0010800635



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 189/А0150058  
АХГ-2022/158/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн урсгал зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсвийн зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг хэмнэлттэй үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах, хэмнэлттэй ажиллаж, зөрчлийг арилгах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Захирагч Г.Ганзориг, Ерөнхий нягтлан бодогч Г.Балцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
А.ЦЭРЭНЧИМЭД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264231

\\10.10.10.20\Bicfig\_Kherig\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-196.Docx

0010800631





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 190/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/158/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангаар 5 байгууллагатай холбоотой 10,956.320.00 төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тооцоо үүссэн харилцагч тус бүрээр авлагын тооцоо хийж, баталгаажуулан, баримтжуулах, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Захирагч Г.Ганзориг, Ерөнхий нягтлан бодогч Г.Балцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН**  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХҮК-ИЙН  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
А.ЦЭРЭНЧИМЭД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-195.Docx

0010800628



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 232/А0150058  
АХГ-2022/158/НА-ГАА-ТМЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 139 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 15 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлж, өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-ын "цалингийн зардлаас бусад таван сая дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр гүйлгээний утга, хүлээн авагчийн нэр"-ийг тухай бүр нь мэдээлнэ гэсэн заалтууд, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2.10-ын "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол улсын Ерөнхий аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан журмын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчил давтан гарсан тул ерөнхий нягтлан бодогч Г.Балцэцэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны захирагч Г.Ганзоригт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

А.ЦЭРЭНЧИМЭД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264280

90.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-130.Docx

0010800340





